



МОНГОЛ БАНКНЫ
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТУШААЛ

2007 оны 07 сарын 02 өдөр

Дугаар 312

Улаанбаатар хот

Журам батлах тухай

“Төв банк (Монголбанк)-ны тухай хууль”-ийн 19.1, 28.1.2 дахь заалт, “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль”-ийн 4.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс сэргийлэх, түүнтэй тэмцэхэд харилцагчийг таньж мэдэх талаар банкны баримтлах журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. Энэхүү тушаалаар батлагдсан журмыг хэрэгжүүлж ажиллахыг банкуудын захирал нарт даалгасугай

3. Энэ тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шалгалтын газар (Ж.Ганбаатар), Санхүүгийн мэдээллийн алба (Б.Төмөрбат)-д даалгасугай.

ЕРӨНХИЙЛӨГЧ

А.БАТСҮХ

Tushaal2007.doc

14 0667

**МӨНГӨ УГААХ, ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХЭЭС СЭРГИЙЛЭХ,
ТҮҮНТЭЙ ТЭМЦЭХЭД ХАРИЛЦАГЧИЙГ ТАНЬЖ МЭДЭХ ТАЛААР
БАНКНЫ БАРИМТЛАХ ЖУРАМ**

НЭГ. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх (цаашид “МУТС” гэх)-тэй тэмцэх, түүнээс сэргийлэхэд банкны хэрэгжүүлэх үйл ажиллагаатай холбогдох харилцааг зохицуулахад оршино.

1.2. Банк нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэхэд харилцагчийг сайн таньж мэдсэнээр зах зээлийн хөгжлийг дэмжин, санхүүгийн тогтолцоог илүү тод болгох, харилцагчийн шударга бизнесийг хөхиүлэн, сайн засаглалыг дэмжих, залилан мэхэлж хөрөнгө мөнгө завших зэрэг санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэж, урьдчилан сэргийлэн, банкны байгууллагын нэр хүндийг хамгаалах зорилготой.

1.3. Энэхүү журамд дараахь нэр томъёог дор дурдсан утгаар хэрэглэж ойлгоно:

1.3.1. “Харилцагчийн талаарх мэдээллийг шалгах” гэж харилцагчийг таниж мэдэх зорилгоор Монгол Улсын хууль тогтоомжоор хориглоогүй харилцагчийн тухай мэдээллийг харилцагчаас гаргуулж авах, олж авах, тухайн мэдээллийн үнэн зөвийг тогтоох зорилгоор албан ёсны бичиг баримт, төрийн байгууллагын мэдээллийн сан болон мэдээллийн бусад эх үүсвэрийг ашиглахыг.

1.3.2. “Харилцагчийн тухай албан ёсны бичиг баримт” гэж тухайн харилцагч хувь хүний бүтэн нэр, цээж зураг, төрсөн он, сар, өдөр, баримтын дугаар бүхий төрийн байгууллагаас олгосон хугацаа нь хүчинтэй бичиг баримтыг хэлнэ. */Монголбанкны Ерөнхийлөгчийн 2007 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн 547 дугаар тушаалаар нэмсэн/*

1.3.3. “Харилцагч” гэж тухайн банкнаас ямар нэгэн санхүүгийн үйлчилгээ авч буй данстай болон дансгүй хувь хүн, хуулийн этгээдийг хэлнэ. */Монголбанкны Ерөнхийлөгчийн 2007 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн 547 дугаар тушаалаар нэмсэн/*

1.4. Банк нь МУТС үйл ажиллагаатай холбоотой хууль бус үйлдэлд өртөхөөс сэргийлэх үүднээс энэ талаар цогц бодлого, хөтөлбөр, дотоод журам (МУТС-тэй тэмцэх дотоод журам)-ыг боловсруулж, дагаж мөрдөнө.

1.5. Банк нь МУТС-тэй тэмцэх талаарх өөрийн дотоод журмын дагуу харилцагчийн эрсдлийн ерөнхий түвшинг тогтоох, их хэмжээний эрсдэл дагуулсан харилцагчийн дансыг тусгайлан хянах, тогтсон хэм хэмжээнээс гадуурхи гүйлгээг нягтлан шалгах зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

1.6. Банк, түүний нэгжийн хэмжээ, үйл ажиллагааны цар хүрээ, байршил, төрлөөс шалтгаалж харилцагчийг таньж мэдэх шаардлага өөр байж болно.

1.7. Банк харилцагчийн МУТС үйл ажиллагаанд холбогдох эрсдлийн ерөнхий түвшинг тогтоосны үндсэн дээр түүний талаарх мэдээллийг хялбаршуулсан, энгийн болон өндөржүүлсэн хэлбэрээр шалгана.

ХОЁР. Харилцагчийг таньж, мэдэх шаардлага

2.1. Банк нь харилцагчийг таньж мэдэх (цаашид “ХТМ” гэх) шаардлагыг хэрэгжүүлэх зорилгоор шаардлагатай мэдээллийг харилцагчаас гаргуулах, гаргуулан авсан мэдээллээ шалгах эрхтэй.

2.2. МУТС-тэй тэмцэх хуулийн 5 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу гүйлгээ хийх болон санхүүгийн бусад үйлчилгээ үзүүлэхээс өмнө энэ журмын 1.5, 1.6-д зааснаас үл хамааран харилцагчаас дараахь мэдээллийг гаргуулж авна:

2.2.1. Харилцагч нь иргэн бол түүний овог, эцэг (эх)-ийн нэр, өөрийн нэр, оршин суугаа хаяг, регистрийн дугаар, холбоо барих утасны дугаар; */Монголбанкны Ерөнхийлөгчийн 2007 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн 547 дугаар тушаалаар өөрчлөлт орсон/*

2.2.2. Харилцагч нь хуулийн этгээд бол түүний нэр, албан ёсны хаяг, улсын бүртгэлийн болон татвар төлөгчийн дугаар, харилцах утасны дугаар, төлөөлөн үйл ажиллагаа явуулах эрх бүхий этгээдийн нэр, хаягийг авна; */Монголбанкны Ерөнхийлөгчийн 2007 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн 547 дугаар тушаалаар өөрчлөлт орсон/*

2.2.3. Гүйлгээний мөнгөн дүн, утга, төлбөр хүлээн авагчийн тухай мэдээлэл; */Монголбанкны Ерөнхийлөгчийн 2007 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн 547 дугаар тушаалаар өөрчлөлт орсон/*

2.2.4. Бэлэн бус шилжүүлэг хийсэн этгээдийн тухай мэдээлэл; */Монголбанкны Ерөнхийлөгчийн 2007 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн 547 дугаар тушаалаар өөрчлөлт орсон/*

2.2.5 Данс нээх үед энэ журмын 2.2.1, 2.2.2, 2.2.3 болон 2.2.4-т заасан мэдээллээс гадна харилцагч нь иргэн бол түүний иргэний үнэмлэхийн нотариатаар гэрчлүүлсэн хуулбар, хуулийн этгээд бол түүний улсын бүртгэлийн гэрчилгээний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар, удирдлагын талаархи дэлгэрэнгүй танилцуулгыг авна. */Монголбанкны Ерөнхийлөгчийн 2007 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн 547 дугаар тушаалаар өөрчлөлт орсон/*

2.3. Банк нь МУТС-тэй тэмцэх хуулийн 5 дугаар зүйлийн 1-т заасны дагуу дараахь тохиолдолд харилцагчийн талаархи мэдээллийг шалгана:

2.3.1. Монголбанкнаас зөвшөөрөгдсөн санхүүгийн үйлчилгээ үзүүлэхийн өмнө,

2.3.2. 20 сая төгрөг (түүнтэй тэнцэх гадаад валют) буюу түүнээс дээш үнийн дүнтэй гүйлгээ хийхийн өмнө,

2.3.3. Хоорондоо холбоо бүхий хэд хэдэн удаагийн гүйлгээний тус бүрийн үнийн дүн нь 20 сая төгрөгөөс бага боловч нийт үнийн дүн нь 20 сая төгрөг (түүнтэй тэнцэх хэмжээний гадаад валют) буюу түүнээс дээш үнийн дүнтэй бөгөөд энэхүү гүйлгээ нь энэ журмын 2.2-т заасан мэдээллийг гаргаж өгөхөөс зайлсхийх зорилго агуулсан гэж үзэх үндэслэл байгаа бол,

2.3.4. Харилцагчийн талаар өмнө авсан мэдээллийн үнэн зөв эсэхийг банк шалгах шаардлагатай бол,

2.3.5. Гадаад төлбөр тооцооны гүйлгээ хийхийн өмнө,

2.3.6. Тухайн харилцагчийг буюу гүйлгээг мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаатай холбоотой гэж үзэх бусад үндэслэл байгаа бол,

2.4. Харилцагч энэ журмын 2.2-т заасан мэдээллийг өгөхөөс татгалзвал банк данс нээх, гүйлгээ хийх, санхүүгийн бусад үйлчилгээ үзүүлэхээс татгалзах үүрэгтэй.

2.5. Банк нь өөрийн харилцагчийн талаарх мэдээллийг МУТС-тэй тэмцэх хуулийн 5.4 дүгээр зүйлтэй нийцүүлэх бөгөөд цаашид энэхүү мэдээлэлд орсон нэмэлт, өөрчлөлт бүрийг бүртгэж, уул мэдээллийн багцыг 2 жил тутам шинэчилж байна.

2.6. Банкинд дараахь үйл ажиллагааг хориглоно:

2.6.1. нэргүй, дугаарласан эсхүл хуурамч нэрээр данс нээх, гүйлгээ хийх, хаагдсан данс ашиглах,

2.6.2. гадаад улсад бүртгэгдсэн гэх боловч биетээр оршдоггүй, тухайн орны санхүүгийн зохицуулалтад үл хамрагдах банк, байгууллага болон тэдгээртэй харилцдаг банк, хуулийн этгээдтэй харилцаа тогтоох.

2.7. Банк гадаад орны харилцагч банк, байгууллагатай харилцаа тогтоохдоо тухайн харилцагч банк, байгууллагын талаарх энгийн мэдээллээс гадна дараахь мэдээллийг шалгана:

2.7.1. Тухайн банк, байгууллагын бизнесийн мөн чанарыг тодорхойлох мэдээлэл цуглуулах,

2.7.2. Тухайн улсын банкны хяналт шалгалтын байгууллага болон олон нийтийн мэдээллийн эх үүсвэрээс тухайн банк, байгууллагын үйл ажиллагаа, нэр хүндийн талаар мэдээлэл авах,

2.7.3. Тухайн банк, байгууллагын МУТС-тэй тэмцэх тогтолцоо, дотоод хяналтын хөтөлбөрийг судлах,

2.7.4. МУТС-тэй тэмцэх үйл ажиллагаанд холбогдон шалгагдаж байсан эсэх талаар лавлагаа авах.

2.8. Банк нь ХТМ шаардлагыг хэрэгжүүлэхэд хүндрэл үүсгэж МУТС эрсдэл (зайнаас харилцаа тогтоох гэх мэт)-ийг бий болгож болзошгүй шинэ техник, технологид онцгой анхаарч, МУТС-тэй тэмцэх талаарх дотоод журамдаа тухайн эрсдлээс сэргийлэх тодорхой арга хэмжээг тусган хэрэгжүүлнэ.

2.9. Харилцагчаас банкинд данс нээснээс хойш түүний өгсөн мэдээлэл буруу, ташаа болох нь тогтоогдвол, банк харилцагчаас энэ тухай тайлбар гаргуулах бөгөөд тайлбар өгөхөөс татгалзах, мэдээлэл нь хуурамч, үндэслэлгүй бол дансыг хааж, хөрөнгийг буцааж олгоно.

2.10. Данстай харилцагч бүрийн иргэний үнэмлэх, улсын бүртгэлийн гэрчилгээний нотариатаар гэрчлүүлсэн хуулбарыг банк өөртөө авч хадгалах бөгөөд данстай харилцагчийн иргэний үнэмлэх, улсын бүртгэлийн гэрчилгээн дэх мэдээлэл өөрчлөгдөх бүр түүнийг шинэчлэнэ. */Монголбанкны Ерөнхийлөгчийн 2007 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн 547 дугаар тушаалаар нэмсэн/*

ГУРАВ. Данс, гүйлгээг тусгайлан хянах

3.1. Банк дор дурдсан данс, гүйлгээг тусгайлан хянах үүрэгтэй:

3.1.1. 20 сая төгрөг (түүнтэй тэнцэх хэмжээний гадаад валют) буюу түүнээс дээш үнийн дүнтэй гүйлгээ,

3.1.2. Тухайн гүйлгээний утга нь тодорхой бус,

3.1.3. Бэлэн бус шилжүүлэг хийсэн, эсхүл шилжүүлэг хийлгэсэн этгээдийн тухай бүрэн мэдээлэлгүй,

3.1.4. МУТС-тэй тэмцэх тогтолцоо хангалтгүй, МУТС гэмт хэрэг их гардаг улс, бүс нутагт оршин суудаг харилцагчийн дансанд,

3.1.5. Монголбанкны Ерөнхийлөгчийн баталсан жагсаалтад орсон гадаад улсын төрийн албан тушаалтан болон улс төрийн намын удирдлагын нэр дээр хийгдэх гүйлгээ,

3.1.6. Тухайн харилцагчийн урьд нь хийж байснаас өөр бөгөөд утга нь тодорхойгүй гүйлгээ.

3.2. Банк дээрх гүйлгээний талаар нэмэлт мэдээлэл, тайлбар гаргуулах зэргээр бололцоотой бүх арга хэмжээг авна.

3.3. Банк нь ХТМ шаардлагын хүрээнд түүний эрсдлийн түвшинг тогтоож, өндөр эрсдэлтэй харилцагчийн данс, гүйлгээнд тусгайлан хяналт тавина.

3.4. Харилцагчаас банкинд нэмэлт мэдээлэл, тайлбар өгөхөөс татгалзаж байвал банк харилцагчтай байгуулсан гэрээг цуцлах эрхтэй.

ДӨРӨВ. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх талаар банкнаас хэрэгжүүлэх арга хэмжээ

4.1. Банк МУТС-тэй тэмцэх тухай хуулийн 14 дүгээр зүйлд заасны дагуу МУТС-тэй тэмцэх арга хэмжээний хүрээнд дотоод хяналтын хөтөлбөрийг баталж мөрдөх бөгөөд МУТС-тэй тэмцэх хууль, МУТС-тэй тэмцэх дотоод журмын хэрэгжилтийг хариуцах, байнгын хяналт тавих, дурдсан асуудлаар банкны ажилтнуудын мэдлэгийг дээшлүүлэх, сургалт зохион байгуулах үүрэг бүхий ажилтан (алба)-тай (цаашид “хэрэгжилт хариуцсан ажилтан” гэх) байна.

4.2. Банк МУТС-тэй тэмцэх дотоод хяналтын хөтөлбөрийн хүрээнд банкнаас хийх ажлыг зохион байгуулах, боловсронгуй болгох арга хэмжээг тогтмол авна.

4.3. Банкны Төлөөлөн удирдах зөвлөл нь энэ журмын 4.1 дэх заалтын хэрэгжилтэд хяналт тавин ажиллана.

4.4. Хэрэгжилт хариуцсан ажилтан нь банкны дотоод журмын биелэлтийг улирал тутам банкны Төлөөлөн удирдах зөвлөлд тайлагнах ба тайлангийн хувийг СМА-нд бичгээр ирүүлнэ.

4.5. Банк нь хэрэгжилт хариуцсан ажилтны аюулгүй байдлыг хангах арга хэмжээг авна.

ТАВ. Мэдээлэл хадгалах

5.1. Банк нь корреспондент, банк хоорондын гүйлгээ болон гадаад төлбөр тооцооны баримт бичгийг 5-аас доошгүй жилийн хугацаанд хадгална.

5.2. Банк нь харилцагчийн нэр, хаягийг тогтоосон баримт, тухайлбал иргэний үнэмлэх түүнтэй адилтгах бичиг баримт, жолооны үнэмлэхийн хуулбар, данс бүртгэлийн болон бичиг хэргийн харилцааны талаарх мэдээллийг холбогдох данс хаагдсанаас хойш 5 жилээс доошгүй хугацаанд хадгална.

5.3. Банк нь харилцагчийн мэдээллийн бүртгэлээс тухайн гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээг, тухайлбал гүйлгээний дүн, арилжаа хийсэн валютын талаарх тэмдэглэл зэргийг гаргуулан авах, мөн шаардлагатай тохиолдолд эдгээр баримт бичгийг хуулийн байгууллага шалгахад нотлох баримтын хэмжээнд ашиглах бололцоотойгоор хадгална.

ЗУРГАА. Төрийн эрх бүхий байгууллагатай хамтран ажиллах

6.1. Банк нь МУТС-тэй тэмцэх дотоод журмаа хэрэгжүүлэхдээ Монголбанк болон төрийн эрх бүхий байгууллагатай хууль тогтоомжийн хүрээнд хамтран ажиллана.

6.2. Санхүүгийн мэдээллийн албанд хүргүүлэх тайлан, мэдээнээс бусад тохиолдолд банк Банкны тухай хуулийн 6 дугаар зүйл, Монголбанкны Ерөнхийлөгч, Улсын Ерөнхий Прокурорын хамтарч баталсан “Мэдээлэл өгөх журам”-д заасны дагуу эрх бүхий байгууллагаас ирүүлсэн албан ёсны бичгээр ирүүлсэн хүсэлтийн дагуу харилцагчийн гүйлгээ, дансны тухай мэдээллийг гаргаж өгнө.

6.3. МУТС-тэй тэмцэх хуулийн дагуу Санхүүгийн мэдээллийн албаны эрх бүхий албан тушаалтан банк, түүний харилцагчийн данс, гүйлгээнд хяналт тавьж, мэдээллийг нягтлан шалгах зорилгоор банкны байранд нэвтрэх, хяналт шалгалт хийх, банкны удирдлага, ажилтнаас мэдээлэл авах, тухайн гүйлгээг 3-аас дээшгүй хоногийн хугацаанд түдгэлзүүлэх эрхтэй.

ДОЛОО. МУТС-тэй тэмцэх дотоод журмын биелэлт, хэрэгжилтийг тайлагнах, хяналт тавих

7.1. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх бодлогын хэрэгжилт хариуцсан алба, ажилтны төсөв, төлөвлөгөөний биелэлт, тэдгээр нь хууль зүйн хүрээнд үйл ажиллагаа явуулж байгаа эсэхэд банкны дотоод хяналтын нэгж тогтмол хяналт тавьж банкны ТУЗ болон хувь нийлүүлэгч нарт тайлагнана.

7.2. Банк мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх ажлын хүрээнд хийж гүйцэтгэсэн ажлын тайланг нийтэд мэдээлж болно.

7.3. Банк МУТС-тэй тэмцэх бодлогын хүрээнд батлагдсан дотоод журам, заавар, тэдгээрийн нэмэлт, өөрчлөлтийг тогтоосон журмын дагуу Монголбанк буюу СМА-нд хүргүүлж, бүртгүүлж байна.

НАЙМ. Харилцагчдад мэдээлэх, сурталчлах

8.1. Банк нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй хэрхэн тэмцэж буй талаар хэрэгжүүлж буй бодлого, дотоод журам, тэдгээрийн ач холбогдол, үр ашиг, энэ талаархи хууль тогтоомжид гарч буй нэмэлт, өөрчлөлт, онцлогийн тухай харилцагчдад тогтмол мэдээлж, сурталчилна.

ЕС. Хариуцлага

9.1. Энэхүү журмыг зөрчсөн этгээдэд Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 21 дүгээр зүйлд заасан хариуцлага хүлээлгэнэ.

-----oO-----